



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛМОГО-2015

*Хүмүүнд төр эрхэм
Морд хүмүүн эргэдэг*

ИРГЭН ТА

www.lso.mn цахим хуудсанд хандаж
өөрийн мэдээлээ баталгаажуулна уу



ОРОН ДАЯАР 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫГ ДУУСТАЛ ЯВАГДАНА.

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?


www.1212.mn




СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН



www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.



Monstat ezStat
аппликейшн



1900-1212



Лавлах утас



Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН



Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

@statistic_mn



Статистик
мэдээлэл

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	5
Үндсэн үзүүлэлтүүд.....	13
I. 1 Хөдөлмөр	14
I. 2 Нийгмийн даатгал.....	15
I. 3 Эрүүл мэнд	15
I. 4 Гэмт хэрэг	16
II.1 Төсөв	18
II.2 Үнэ.....	19
II.3 Хөдөө аж ахуй	
Мал аж ахуй	21
Газар тариалан	28
II.4 Аж үйлдвэр	33

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажил хайгч иргэд 2015 оны 10 дугаар сарын эцэст 697 болсны 376 нь эмэгтэйчүүд байна. 2015 оны эхний 10 сард ажилгүй 298 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 182 иргэн ажил зуучлагдан орж, 404 иргэн ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 42 хүн буюу 12.4 хувиар буурч, ажилд зуучлагдан орсон иргэд 71 хүнээр буюу 63.9 хувиар, ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 120 хүнээр буюу 42.5 хувиар өсчээ.

Зураг I.1

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон болон хасагдсан иргэд жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 49.2 хувийг бүрэн дунд, 20.1 хувийг магистр, доктор, бакалаврын боловсролтой, 15.8 хувийг суурь, 10.3 хувийг тусгай мэргэжлийн дунд болон техник мэргэжлийн, 3.7 хувийг бага, 0.9 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр 2015 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар, хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй, ажилгүй иргэдийн 33.5 хувийг 25-34 насныхан, 27.3 хувийг 35-44 насныхан, 20.1 хувийг 45-54 насныхан, 13.3 хувийг 15-24 насны залуучууд, 5.8 хувийг 55-аас дээш насны хүмүүс эзэлж байна.



I.2. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2015 оны эхний 10 сард 8324.1 сая төгрөг, зарлага 24157.8 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 1121.8 сая төг буюу 15.6 хувь, зарлага 3272.2 сая төг буюу 16.9 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 1121.8 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 225.3 сая.төг буюу 4.3 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 29.7 сая.төг буюу 5.0 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 10.1 сая.төг буюу 7.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 3272.2 сая.төг буюу 15.6 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 2859.9 сая.төг буюу 15.6 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 126.6 сая. төг буюу 16.8 хувиар, ҮОМШӨДаатгалын сан 215.7 сая.төг буюу 2.3 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2015 оны эхний 10 сард 2805.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 618.5 сая.төг буюу 32.0 хувиар өсчээ. Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр тэтгэмжийн 553.9 сая.төг буюу 19.7 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжид, 720.1 сая.төг буюу 25.6 хувийг алдарт эхийн одонгийн тусламж, 48.2 сая.төг буюу 1.7 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламжид, 245.0 сая.төг буюу 8.7 хувийг хүнс тэжээлийн хөтөлбөрт зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс алдарт эхийн одонгийн тусламж 0.9 хувиар өсч, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж 5.5 хувиар, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж 81.0 хувиар буурчээ.




1.3 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 10 сард 849 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 856 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 3 буюу 0.4 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 2 буюу 0.3 хувиар буурсан байна.

Зураг 1.3

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Аймгийн хэмжээнд нялхасын эндэгдэл 2015 оны эхний 10 сард 17 болж, өмнөх оны мөн үеийнхээс 5 хүүхэд буюу 21.4 хувиар өсч, 5 хүртэлх насандаа 1 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүүхэд буюу 66.7 хувиар буурчээ.

Зураг 1.4

Эндсэн хүүхэд, жил бүрийн эхний 10 сарын байдлаар




1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2015 оны эхний 10 сард 20 тохиолдол, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0.1 болж, өмнөх оны мөн үеийнхээс нялхасын эндэгдэл 6-аар нэмэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3-аар буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2015 оны эхний 10 сард 337 болж, өмнөх оны мөн үеийнхээс 8 тохиолдол буюу 2.4 хувиар нэмэгдэхэд амьсгалын замын халдварт өвчин 18 буюу 17 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 186 буюу 55.2 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг 1.5

10000 хүнд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсөд, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Аймгийн хэмжээнд ХДХВ/ДОХ-ын тохиолдол илрээгүй байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 19 байна.




I.4 Байгаль орчин

Цаг уурын урьдчилсан мэдээ

Агаарын температурын сарын дундаж нь 8-13 градус хүйтэн байх бөгөөд олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард нутгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй байна.

Зураг I.6

10-р сарын агаарын температурын хоногийн явц



Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх тухай

11-р сарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нийт нутгаар олон жилийн дунджийн орчим, хур тунадас мөн олон жилийн дунджийн орчим байх ба Баян-Агт, Сайхан, Могод, Гурванбулаг зэрэг сумдад дунджаас ахиу орох төлөвтэй байна.

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2015 оны эхний 10 сард 125 удаа гарч, 8 хүн амь насаа алдаж, 50.4 мян.толгой мал, амьтан хорогджээ. Харин объектын түймэр 38 удаа гарч, аюулт үзэгдэл, осол гэмтлийн улмаас 497.8 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтад 2015 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеийнхээс 49.9 мян.толгойгоор нэмэгдсэн байна. Нийт хорогдсон малын 0.9 хувь нь халдварт өвчнөөр өвчилөн устгагдсан байна.

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол өмнөх оны үеийнхээс 39 буюу 45.3 хувиар нэмэгджээ.

Хүснэгт I.1

Аюулт үзэгдэл, осол, жилийн бүрийн 10 сарын байдлаар*

	2013 I-X	2014 I-X	2015 I-X	2015 X / 2014 X
Аюултай үзэгдэл ослын тохиодлын тоо	57	86	125	145.3
Аюултай үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	22	11	8	72.7
Шатсан гэр, орон сууцны тоо	14	14	32	2.2**
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьд	15	544	50452	9.2**
Обектын түймрийн тоо	24	30	38	126.7
Учирсан хохирлын хэмжээ (сая.төг)	144.4	295.8	497.8	168.3

* - Аймгийн Онцгой байдлын газрын мэдээлэл

** - Дахин их




I.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 10 сард 255 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 42 хэрэг буюу 14.1 хувиар буурчээ.

Гэмт хэргийн гаралт Бүрэгхангай, Орхон, Баяннуур, Дашинчилэн, Рашаант сумдад өмнөх оны мөн үеийнхээс өсч, Баян-Агт, Хутаг-Өндөр, Гурванбулаг, Сайхан, Тэшиг, Сэлэнгэ, Хялганат, Хангал, Булган, Могод сумдад өмнөх оны мөн үеийнхээс буурч, Бугат, Баяннуур, Хишиг-Өндөр сумдад урьд оны мөн үеийнхтэй ижил түвшинд байна.

Зураг I.7

Бүртгэгдсэн гэмт хэрэг, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад хулгайн гэмт хэрэг 27 буюу 23.5 хувиар, танхайн гэмт хэрэг 7 буюу 63.6 хувиар, бусад төрлийн гэмт хэрэг 16 буюу 45.7 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг 96 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 24.4 хувиар, яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг 62 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 13.9 хувиар буурч, хэргийн илрүүлэлт 65.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 6,2 пунктээр өссөн байна.

Хүүхэд оролцсон гэмт хэрэгт холбогдогсад 20 буюу өмнөх оны мөн үеийнхээс 74.4 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэргийн холбогдогсад 12 буюу өмнөх оны мөн үеийнхээс 42.9 хувиар, урьд нь ял шийтгэгдэж байсан этгээд 4 буюу 69.2 хувиар буурч, согтуугаар гэмт хэрэг үйлдэгсэд 25 буюу өмнөх оны мөн үеийнхээс 41.7 хувиар өсчээ.

18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 2015 оны эхний 10 сард аймгийн дунджаар 62 болж, өмнөх оны мөн үеийнхээс 11 буюу 15.0 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 120 хүн гэмтэж өмнөх оны мөн үеийнхээс 21 буюу 21.2 хувиар өсч, 15 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 14 хүн буюу 48.3 хувиар буурсан байна.

Зураг I.8

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2015 оны эхний 10 сард 679.9 сая төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 411.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 73.6 сая төгрөг буюу 9.8

хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 56.3 сая төгрөг буюу 15.9 хувиар өссөн байна.

Зураг I.9

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төг



Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 10 сард гудамж талбайд хэвийн бус явсан, орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 440 хүн саатуулагдсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 180 хүн буюу 29 хувиар, захиргааны журмаар 178 хүнийг баривчлах шийтгэл эдлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 59 хүн буюу 24.8 хувиар буурсан байна.

Малын хулгайн гэмт хэрэг 46 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 18 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 11 хэрэг буюу 19.3 хувиар буурсан байна.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 2015 оны эхний 10 сард 15558.6 сая төгрөг, зарлага 15216.0 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 342.6 сая төгрөг буюу 2.2 хувийн эерэг гарлаа.

Зураг II.1

Орон нутгийн төсвийн нийт орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая.төг



Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 1625.9 сая төгрөг буюу 12.1 хувиар буурахад байгалийн нөөц ашигласны төлбөр 1623.0 сая төгрөг буюу 17 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Орон нутгийн төсвийн орлогын 75.9 хувийг татварын орлого, 3.0 хувийг татварын бус орлого, 17.9 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлого, 3.2 хувийг улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүжилт эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс орон нутгийн төсөвт олгох санхүүжилтийн эзлэх хувь 9 пунктээр, татварын бус орлогынх 2.3 пунктээр буурч, харин татварын орлогынх 15.9 пунктээр өсчээ.

Аймгийн төвсийн зарлагын хэмжээ 2015 оны эхний 10 сард 15216.0 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2425.8 сая.төг буюу 18.9 хувиар өсчээ.




II.2 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2015 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.9 хувиар буурч, оны эхнээс 1.8 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 4.2 хувиар өслөө.

Зураг II.2

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)



Хүснэгт II.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Бараа, үйлчил-гээний бүлэг	Жин	2015 X 2014 X	2015 X 2014 XII	2015 X 2015 IX
Ерөнхий индекс	100	104.2	101.8	99.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	105.1	99.8	96.9
Согтууруулах ундаа, тамхи	3.2	106.1	101.6	100.2

Хувцас, бөс, бараа, гутал	16.1	100.4	97.4	98.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	103.8	102.1	99.9
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	102.0	102.0	98.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	99.2	99.2	100.0
Тээвэр	12.2	103.9	103.9	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	110.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	103.6	99.9	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	132.5	132.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	117.2	113.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	104.4	104.4	103.3

Зураг II.3

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2015 оны I-X сар, (өмнөх сар=100%)



Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2015 оны 10 дугаар сард адууны шир 27.2 мян.төг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 26.0 мян.төг, 2.3 м-ээс дээш урттай шир 45.0 мян.төг, хонины нэхий 1.5 мян.төг, ямааны арьс 4.3 мян.төг байна.

Малын дундаж үнэ: 2015 оны 10 дугаар сард шүдлэн эр үхэр 582.1 мян.төг буюу өмнөх оны мөн үеийнхээс 21.3 хувиар, эм хонь 95.0 мян.төг буюу 24.4 хувиар буурчээ.



II.3 Статистикийн бизнес регистрийн сан

Статистикийн зорилгоор ашигладаг аж ахуйн нэгж байгууллагын регистрийн санд 2015 оны эхний 10 сард 1197 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагийн 1041 буюу 87.0 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын 451 буюу 37.7 хувь нь Булган суманд ногдож байна.



II.4 Хөдөө аж ахуй Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2014 оны эцэст тоологдсон төллөх насны 1396.3 мянган хээлтэгч малын 1201.0 мянга буюу 86.0 хувь нь эхний 10 сард төллөсөн байна. Эм хонины 88.8 хувь, үнээний 88.8 хувь, эм ямааны 84.6 хувь, гүүний 75.6 хувь, ингэний 47.3 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 90.7 хувь буюу 1089.1 мянган төл бойжиж байгаа нь өмнөх мөн үеийнхээс 22.7 мянга буюу 2 хувиар буурсан байна.

Зураг II.4

Төллөсөн хээлтэгч, сумаар, 2015 оны 10 эхний 10 сард




Том малын зүй бусын хорогдол 2015 оны эхний 10 сард аймгийн хэмжээнд 61.7 мян. толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 50 мян.толгой буюу 5.3 дахин нэмэгдсэн байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 3.6 мянга, үхэр 3.2 мянга, тэмээ 7 толгой, хонь 31.8 мянга, ямаа

23.0 мянга байна. Нийт хорогдлын 51.5 хувийг хонь, 37.2 хувийг ямаа эзэлж байна. Өвчнөөр хорогдсон мал 2015 оны эхний 10 сард 2.5 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс мянга буюухувиар өсчээ.

Зураг II.5

Зүй бусаар хорогдсон мал, сумаар, 2015 оны эхний 10 сард



Газар тариалан

Ургац хураалтын мэдээгээр аймгийн хэмжээнд 2015 оны 11-р сарын 1-ний байдлаар 28.9 мян.т үр тариа, 5.1 мян.т төмс, 2.2 мян.т хүнсний ногоо, 0.4 мян.т тэжээлийн ургамал, 0.7 мян.т техникийн ургамал хурааж, 66.5 мян.т өвс хадлан, 1.7 мян.т гар тэжээл, бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс үр тариа 18.8 мян.т буюу 39.4 хувь, төмс 2.1 мян.т буюу 29.2 хувь, хүнсний ногоо 1.4 мян.т буюу 41.6 хувь, бэлтгэсэн хадлан 26.2 мян.т буюу 28.3 хувиар буурч, гар тэжээл 6.2 хувиар өссөн байна.

Зураг II.6

Ургац хураалт, өвс хадлан, гар тэжээл, жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний байдлаар, мян.т





II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2015 оны эхний 10 сард 6050.4 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 7029.1 сая.төг буюу 53.7 хувиар буурлаа. Үүнд уул уурхай, олборлох үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 407.9 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 7313.9 сая.төг буюу 94.7 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

Хүснэгт II.2

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар сая.төг

Аж үйлдвэрийн салбар	2014		2015		2015 I-X 2014 I-X
	X	I-X	X	I-X	
Нийт дүн	3527.1	13079.5	1703.7	6050.3	46.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	2941.0	7721.9	130.2	407.9	5.3
Боловсруулах аж үйлдвэр	487.6	4181.7	1387.3	4174.8	99.8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	98.5	1175.9	186.2	1467.6	124.8

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 10 дугаар сард 1703.7 сая.төг болж, өмнөх сарынхаас 1521.4 сая.төг буюу 51.7 хувиар буурлаа. Үүнд уул уурхай, олборлох үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2810.8 сая.төг буюу 4.4 дахин буурсан нь нөлөөлж байна.

Өмнөх оны мөн үеийнхээс боловсруулах аж үйлдвэрийн салбарт үр тарианы гурилын үйлдвэрлэлт 1.4 мян.т буюу 3.1 дахин өссөн байна. Харин уул уурхайн салбарын төмрийн хүдрийн олборлолтын үйл ажиллагаа түр зогссон, чулуун нүүрс олборлолтын үйл ажиллагаа 10 дугаар сараас эхлэсэн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2015 оны эхний 10 сард 9346.6 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3096.7 сая.төг буюу 15.5 хувиар өссөн байна. Нийт борлуулалтыг дотоодын зах зээлд борлуулсан байна. Борлуулалт өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд гурил, гурилан бүтээгдэхүүн, малын тэжээлийн борлуулалт 2846.8 сая.төг буюу 99.2 өссөн нь нөлөөлжээ.

Зураг II.7

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, дэд салбараар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, дүнд эзлэх хувь




II.6 Барилга

Барилгын байгууллагууд 2015 оны эхний 10 сард нийт 8406.5 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 182.2 сая.төг буюу 2.1 хувиар буурчээ.

Барилга угсралт их засварын ажлын 26.5 хувийг орон сууцны барилга, 54.8 хувийг орон сууцны бус барилга, 18.6 хувийг инженерийн барилга байгууламж эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 16.9 пунктээр буурч, орон сууцны бус барилгын ажлынх 34.2 пунктээр, инженерийн барилга байгууламжийнх 9 пунктээр өссөн байна.

Зураг II.8

Барилга, угсралт их засварын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 10 сард, сая.төг





II.7 Тээвэр, холбоо


Тээвэр

Аймгийн тээврийн салбар нь 2015 оны 10 сард 1.0 мян.т ачаа, давхардсан тоогоор 22.9 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 4.9 мян.т буюу 83 хувиар, зорчигчдын тоо 14.6 мян.хүн буюу 39.2 хувиар буурчээ.

Авто тээврийн орлого 31.5 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4.9 сая.төг буюу 18.4 хувиар өссөн байна.

Зураг II.9

Хуурай замын тээврээр тээсэн ачаа, зорчигчдын тоо, жил бүрийн 10 сард



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2013 I-X	2014 I-X	2015 I-X	2015 I-X 2014 I-X
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд				
Төрсөн хүүхэд	880	858	856	99.8
Бүртгэлтэй ажилгүй иргэд 10 дугаар сарын эцэст	838	536	697	130.0
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	484	329	337	102.4
Бүртгэгдсэн гэмт хэрэг	339	297	255	85.9
Макро эдийн засгийн үзүүлэлтүүд				
Орон нутгийн төсвийн орлого, сая.төг	13560.0	13896.9	15558.6	112.0
Орон нутгийн төсвийн зарлага, сая.төг	13215.0	12790.2	15216	119.0
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, суурь үеээс, хувиар	143.2	155.3	161.8	
Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд				
Хураасан ургац, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар, мян.т				
-Үр тариа	55.8	47.7	28.9	60.6
-Төмс	8.5	7.2	5.1	70.8
-Хүнсний ногоо	4.3	3.6	2.2	61.1
-Бэлтгэсэн өвс хадлан	95.9	92.8	66.5	71.7
-Бэлтгэсэн гар тэжээл	1.8	1.6	1.7	106.3
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая.төг				
-Уул уурхай, олборлох аж үйлдвэр	641.5	399	329	82.5
-Боловсруулах аж үйлдвэр	1546.1	3473.2	6491.7	186.9
-Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	1247.6	2377.8	2525.7	106.2
Барилга, угсралт их засврын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 10 сарын байдлаар, сая.төг		8588.7	8406.5	97.9

I.1 ХӨДӨЛМӨР

Үзүүлэлт	2014 I-X		2015 I-X		<u>2015 I-X</u> 2014 I-X	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/	480	227	803	406	167.3	178.9
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	340	136	298	145	87.6	106.6
Тайлант хугацаанд хасагдсан иргэн /идвэхгүйн улмаас/	284	135	404	175	142.3	129.6
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	536	228	697	376	130.0	164.9
Ажилд зуучлагдан орсон иргэн /салбараар/	111	50	182	80	164.0	160.0
Хувьцаат компани	3	3	-	-	-	-
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	44	19	45	20	102.3	105.3
Нөхөрлөл, хоршоо	1	-	-	-	-	-
Төрийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-	-	-
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-	-	-
Төсөвт байгуулага	11	6	52	28	472.7	466.7
Төрийн бус байгууллага	-	-	-	-	-	-
Сан	-	-	-	-	-	-
Бусад	52	22	85	32	163.5	145.5
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	536	228	697	376	130.0	164.9
15-24	96	45	93	53	96.9	117.8
25-34	144	74	234	131	162.5	177.0
35-44	104	54	190	105	182.7	194.4
45-54	116	50	140	73	120.7	146.0
55-59	19	4	30	11	157.9	275.0
60+	1	-	10	3	10**	-
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	536	228	697	376	130.0	164.9
Магистр, доктор	3	2	3	2	100.0	100.0
дипломын болон бакалаврын дээд тусгай мэргэжлийн дунд	68	43	137	91	201.5	211.6
техникийн болон мэргэжлийн бүрэн дунд	279	119	343	182	122.9	152.9
суурь	121	41	110	44	90.9	107.3
бага	24	7	26	8	108.3	114.3
боловсролгүй	7	3	6	2	85.7	66.7

I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ

Үзүүлэлтүүд	2013 I-X	2014 I-X	2015 I-X	2015 I-X 2014 I-X
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	7569	8153.8	8324.1	102.1
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	5141.7	5226.5	5451.8	104.3
Тэтгэмжийн даатгалын сан	541.5	589.5	619.2	105.0
Эрүүл мэндийн даатгалын сан	1397.6	1777	1697.7	95.5
ҮОМШӨ*-ний даатгалын сан	357.4	422.7	407.2	96.3
Ажилгүйдлийн даатгалын сан	130.8	138.1	148.2	107.3
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	15875.22	20892.5	24157.8	115.6
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	13889.5	18335.7	21195.6	115.6
Тэтгэмжийн даатгалын сан	559.5	755.1	881.7	116.8
Эрүүл мэндийн даатгалын сан	1105.6	1507.7	1547.2	102.6
ҮОМШӨ*-ний даатгалын сан	162.12	162.4	378.1	232.8
Ажилгүйдлийн даатгалын сан	158.5	131.6	155.2	117.9

I.3 ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2014 I-X	2015 I-X	2015 I-X 2014 I-X
Амаржсан эхийн тоо	852	849	99.6%
Амьд төрсөн хүүхэд	858	856	99.7%
Эхийн эндэгдэл	-	-	-
Амьгүй төрөлт	1	3	300%
Гэрийн төрөлт	6	6	100%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	12	17	121.4%
Перинаталь эндэгдэл	8	15	187.5%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	14	19.9	142.1%

Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2014 I-X	2015 I-X	2015 I-X 2014 I-X
Нийт гарсан халдварт өвчин	329	337	102%
Гэдэсний халдварт өвчин	8	7	87.5%
Амьсгалын замын халдварт өвчин	106	124	116%
Байгалын голомтот халдварт өвчин	5	1	20%
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	190	186	97.4%
Арьсны халдварт өвчин	23	21	91.3%

I.4 ГЭМТ ХЭРЭГ

Бүртгээгдсэн гэмт хэрэг, сумаар, 10-р сарын байдлаар

Сум	2011 I-X	2012 I-X	2013 I-X	2014 I-X	2015 I-X	2015 I-X % 2014 I-X
Булган	64	79	91	68	52	76.4
Баян-Агт	8	13	13	16	9	56.2
Баяннуур	3	2	5	10	10	100
Бугат	12	13	19	17	17	100
Бүрэгхангай	5	9	15	13	20	153.8
Гурванбулаг	8	9	14	17	11	64.7
Дашинчилэн	14	6	8	14	17	121.4
Могод	11	4	13	10	9	90
Орхон	13	16	33	23	35	152.1
Рашаант	14	16	13	12	13	108.3
Сайхан	14	16	25	13	8	61.5
Сэлэнгэ	8	20	10	14	11	78.5
Тэшиг	6	6	13	7	5	71.4
Хангал	11	14	16	14	5	35.7
Хишиг- Өндөр	7	13	14	16	16	100
Хялганат	6	5	12	10	9	90
Хутаг-Өндөр	7	19	25	23	8	34.7
Бүгд	221	260	339	297	255	85.8

Хулгайн гэмт хэрэг, сумаар, жил бүрийн 10-р сарын байдлаар

Сум	2011 I-X	2012 I-X	2013 I-X	2014 I-X	2015 I-X
Булган	27	36	36	14	15
Баян-Агт	4	9	4	13	2
Баяннуур	1	0	4	7	7
Бугат	6	8	10	6	4
Бүрэгхангай	4	5	7	2	10
Гурванбулаг	7	3	3	7	3
Дашинчилэн	9	3	4	5	12
Могод	8	3	10	4	1
Орхон	1	7	17	13	17
Рашаант	12	6	3	7	4
Сайхан	2	4	20	10	2
Сэлэнгэ	3	9	4	5	1
Тэшиг	1	0	6	2	2
Хангал	1	1	5	2	1
Хишиг-Өндөр	3	2	8	9	4
Хутаг-Өндөр	4	9	12	6	2
Хялганат	1	1	1	3	1
Бүгд	94	106	154	115	88

Сумдын хэргийн илрүүлэлт 2015 оны эхний 10 сарын байдлаар

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг	Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг	Хэргийн илрүүлэлтийн хувь
Булган	18	13	72.20%
Баян-Агт	3	3	100%
Баяннуур	7	5	71%
Бугат	5	3	66.60%
Бүрэгхангай	7	4	57%
Гурванбулаг	3	2	75%
Дашинчилэн	11	5	55%
Могод	4	4	100%
Орхон	19	13	63.10%
Рашаант	4	2	50%
Сайхан	2	1	50.00%
Сэлэнгэ	3	3	100%
Тэшиг	2	1	50%
Хангал	1	0	0%
Хишиг-Өндөр	4	2	50%
Хутаг-Өндөр	1	1	100.00%
Хялганат	2	0	00%
Бүгд	96	62	65,30%

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн 10-р сарын байдлаар

Үзүүлэлт	2011 I-X	2012 I-X	2013 I-X	2014 I-X	2015 I-X	2015 I-X % 2014 I-X
	сая төгрөг					
Учирсан хохирол- Бүгд	340.0	353.0	810	753	679.6	90.3
Үүнээс						
Нөхөн төлүүлсэн	189.7	252	459.5	355.0	411.2	115.8
Нөхөн төлүүлэлтийн хувь	55.8	71.4	56.7	47.1	60.5	128.3

II.1 ТӨСӨВ

ОРЛОГЫН НЭР ТӨРӨЛ	2014 I-X		2015 I-X		2014 I-X	2015 I-X
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлт	
